

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020 оны 05 сарын 22-ний өдөр

Цагаандөрвөлж

1. Дорноговь аймгийн Айраг сумын Засаг даргын Тамгын газар нь Айраг сумын “Хот хөгжлийн төлөвлөгөө” боловсруулах төслийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Айраг сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил болно.

Багц-1 Айраг сумын төвийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг хавсарган ирүүлнэ. Үүнд:

3.1. Компанийн танилцуулга

3.2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар

3.3. Шаардлагатай тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар Үүнд:

- ЗТ-9.2 заалт- Хот тосгоны ЕТ, хэсэгчилсэн ЕТ, суурь судалгаа
- ЗТ-11.1 заалт- Техник, эдийн засгийн үндэслэл
- ЗТ-11.2 заалт- Барилга байгууламжийн төсөв

3.4. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших огноогоор/

3.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших огноогоор /

3.6. Сүүлийн 2 жил буюу 2019, 2018 онуудын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт нотариатаар баталгаажуулах

3.7. Татварын байгууллагын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших огноогоор, татварын өр буюу дутуу үлдэгдэлгүй байх/;

4. Сүүлийн 2 жил буюу 2019, 2018 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт хүснэгтээр ирүүлэх /2019, 2018 оны аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсхүл захиалагч байгууллагын тодорхойлолтыг хавсаргах/

5. Голлох мэргэжилтэн буюу төслийн удирдагч нь газар зохион байгуулалтын мэргэшсэн

/зөвлөх/ инженер байх /мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар зэрэг нотлох баримтыг ирүүлэх/

6. Гадаадын хуулийн этгээд оролцож үл болно.

7. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг дор дурдсан хаягаар авч болох бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 09:00 цагаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn хаягаар нэвтэрч мэдүүлгээ ирүүлнэ үү.

Дорноговь аймаг Айраг сумын Засаг даргын Тамгын газар
Засаг даргын орлогч Б.Амгаланбаатар
Утас 95057705